



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
123 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛ ХОТЫН ХҮН АМЫН ХЭРЭГЦЭЭНД НӨӨЦӨЛСӨН
МАХЫГ БОРЛУУЛАХ ЖУРАМ

Нийслэл хотын хүн амын махны хангамжийг тогтмолжуулах, үнийн хөөрөгдөл гаргахгүй байлгах зорилгоор нийслэл хотын хүн амын хэрэгцээнд нөөцөлсөн махыг борлуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Нэг. Махны хуваарилалт

1.1.Махны нөөцийг бүрдүүлж, борлуулах аж ахуйн нэгж нь дараах үүргийг хүлээнэ.

а/Чанар, эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан мах бэлтгэх;

б/Зориулалтын хөргөх төхөөрөмжид стандартын дагуу хадгалах;

в/Тээвэрлэлтийг зориулалтын хөргөх төхөөрөмжтэй машин, угааж цэвэрлэх, ариутгахад тохиромжтой хулдаас, төмөр зэрэг материалаар доторлосон битүү бүхээг тэвштэй автомашинаар гүйцэтгэх.

1.2.Нөөцийн махыг бэлтгэсэн цэгүүддээ чанар, аюулгүйн баталгаажилтыг ханган хадгалах.

1.3.Махыг бэлтгэсэн цэгүүдээс Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс тогтоосон хугацаанд Улаанбаатар хотын төвлөрсөн

хангамжийн хадгалах байгууллагад тээвэрлэн авчирч хадгалах.

1.4.Хуваарийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс хийх.

1.5.Хуваарийг гаргахдаа дараах нөхцлийг харгалзаж үзэх:

- Дүүргүүдийн хүн амын тоо, нягтрал, хэрэгцээ;
- Борлуулах цэгүүдийн байршил;
- Махны нөөцийг хадгалах, борлуулах цэгүүдийн байршил.

1.6.Махны хуваарийг нийслэлийн дүүргүүдээр гаргаж дүүргүүдийн мах борлуулах цэгүүдэд хуваарилах.

Хоёр. Нөөцийн махны борлуулалт

2.1. Нөөцийн мах борлуулалтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс гүйцэтгэнэ.

2.2.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэр, үйлчилгээний хэлтэс дараах үүргийг хүлээнэ:

а/ Нөөцийн махны хуваарь, мах борлуулах схем гаргах;

б/ Махны борлуулалтын явцыг долоо хоног бүр дүгнэж холбогдох арга хэмжээг зохион байгуулах;

в/ Махны борлуулалт эхэлмэгц борлуулалтын орлогыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн 3109002 тоот дансанд бүрэн хэмжээгээр төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

г/ Нөөцийн махны борлуулалт, үнэ, чанарын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн суртчлах.

Мах худалдаалах төвүүдийн үүрэг

1.Нөөцийн махыг борлуулж байгаа аж ахуйн нэгжид өөрийн худалдааны төвд худалдаалах байр, талбайн хөлс болон мал эмнэлэг-ариун цэврийн хураамжаас бүрэн чөлөөлж, махны үнийг тогтвортой барих бүх боломжоор хангаж ажиллах.

2.Худалдааны төвдөө хотын нөөцийн мах борлуулалтын талаар сурталчилгааг тогтмол хийж, махны лангуу түрээслэгч нарт гарал үүслийн гэрчилгээгүй тусгай зориулалтаас бусад тээврийн хэрэгслээр орон нутгаас ирсэн дайвар бүтээгдэхүүнийг худалдаалуулахгүй байх ажлыг зохион байгуулах.

3.Нөөцийн махнаас гадна Улаанбаатар хотод орон нутгаас ирж байгаа махыг өөрийн худалдааны төвд бөөний үнээр шат дамжлагагүй лангуу болон хэрэглэгчдэд шууд хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын үүрэг

1.Нөөцийн махыг бүрдүүлж, борлуулж аж ахуйн нэгжийн нөөцөлсөн махыг өөрийн үйлдвэрийнх нь мал эмнэлгийн сертификатыг үндэслэн нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтрүүлнэ.

2.Орон нутгаас нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх маханд тухайн орон нутгийн мал эмнэлгийн байгууллагаас үзлэг шинжилгээ хийж олгосон мал эмнэлгийн сертификатыг Авто тээврийн шалган байцаах товчоодод шалгана.

3.Орон нутгаас орж ирж байгаа мал, махны тоо хэмжээг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэст өдөр бүр өгч байх.

Гурав. Махны нөөцийн борлуулалтад тавих хяналт

3.1.Махны нөөцийн бүрдүүлэлт, гэрээний биелэлтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс хяналт тавина.

3.2.Нөөцөлсөн махны чанар, эрүүл ахуй, хадгалалтын байдалд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хяналт тавина.

Дөрөв. Хориглох зүйл

4.1.Махны нөөцийн санг өөр зүйлд зарцуулах, зээлдүүлэх, хандивлах зэрэг зориулалт бусаар ашиглах.

4.2.Чанар аюулгүйн баталгаажилтгүй мах бэлтгэх.

4.3.Мах хадгалах, борлуулах горим зөрчих.

4.4.Махны хэмжээ, хаяг шошгыг дур мэдэн солих.